



ДААТГАЛЫН ХУРААМЖ ГЭЖ ЮУ ВЭ?



Даатгалын хураамж – даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөр.

Даатгалын хураамжийн хэмжээг тогтооход дараах зарчмыг баримтална:



даатгагч, даатгуулагч нарын эрх ашигт нийцсэн байх



тогтвортой байх



нөхөн төлбөр төлөхөд хүрэлцээтэй, үйл ажиллагааны зардлыг бүрэн нөхөхүйц байх



даатгалын бүтээгдэхүүний гэрээний нөхцөлтэй уялдсан байх



хураамжийг нэг удаа бүрэн төлөх, эсвэл даатгалын гэрээний хугацаанд үе шаттайгаар хэсэгчлэн төлөх



эрсдэлд өртөж болзошгүй объект, өртөх магадлал, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрээр ялгавартай тооцох

ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР ГЭЖ ЮУ ВЭ?

Даатгалын нөхөн төлбөр – гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгө.



Жолоочийн даатгалын нөхөн төлбөр: жолоочийн даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгалын гэрээний дагуу даатгагчаас хохирогчид олгох мөнгөн хөрөнгө.

Даатгалын гэрээгээр даатгалын нөхөн төлбөр олгох боломжгүй бол жолоочийн даатгалын сангаас хохирогчид олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгалын нөхөн төлбөрийг хэрхэн олгодог вэ?



Даатгалын компанитай утсаар болон цахимаар яаралтай холбогдож даатгалын тохиолдлыг баталгаажуулах



Холбогдох мэргэжлийн байгууллагад хандах. /Замын цагдаагийн газар, Цагдаагийн газар, Яаралтай түргэн тусламж, ОБЕГ, Гал унтраах анги гэх мэт/



Осол болсон орчин нөхцөлийг харуулан зураг авч баталгаажуулах